



2018 оны 04 дүгээр сарын 27
№16/1021/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Иргэний хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын
хууль**

**Хэлэлцээр соёрхон
батлах тухай**

**Олон улсын
гэрээ**

**Азийн авто замын сүлжээгээр
олон улсын автотээвэрлэлт
гүйцэтгэх тухай Засгийн газар
хоорондын хэлэлцээр**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

155. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 493

156. Хэлэлцээр соёрхон батлах тухай 493

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

157. Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр 494

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн “Энэ хуулийн 67.1.5-д заасан тодорхойлолт, лавлагааг үндэслэн төлбөр гаргуулах хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийг тодорхой тусган, шийдвэр” гэснийг “Шийдвэр” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн



газар хооронд 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

АЗИЙН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭГЭЭР ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү Хэлэлцээрээр үүрэг хүлээхийг хүлээн зөвшөөрсөн улсын Засгийн газрууд (цаашид “Талууд” гэх) нь,

Өөр хоорондын найрамдалт харилцаа, хамтын ажиллагаагаа цаашид хөгжүүлэн бэхжүүлэхийг эрмэлзэн,

Худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорилго болгон,

Найдвартай, үр ашигтай олон улсын автотээвэрлэлт нь өөрийн улсын худалдааны харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрч,

Азийн авто замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын 2004 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хэлэлцээрт заасан авто замын сүлжээнд үндэслэн,

Бусад улсын Засгийн газрыг энэхүү Хэлэлцээрт нэгдэн орохыг уриалан,

Дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор:

“Олон улсын автотээвэрлэлт” гэж дор хаяж нэг Талын улсын хилээр нэвтэрсэн эсхүл/буюу тухайн улсын нутаг дэвсгэрээр өнгөрч буй тээврийн хэрэгслээр хийж байгаа зорчигч болон ачаа тээврийг хэлнэ,

“Тээвэрлэгч” гэж бүртгэлтэй улсынхаа хууль тогтоомжийн дагуу олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх эрх бүхий аль нэг Талын улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ,

“Жолооч” гэж аль нэг Талын эрх бүхий байгууллагаас тээврийн хэрэгсэл жолоодох эрх авсан хувь хүнийг хэлнэ,

“Жолоодох эрхийн үнэмлэх” гэж аль нэг Талын эрх бүхий байгууллагаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг жолоочид олгосон баримт бичгийг хэлнэ,

“Зөвшөөрөл” гэж аль нэг Талын эрх бүхий байгууллагаас өөрийн улсын нутаг дэвсгэрээр нөгөө Талын нутаг дэвсгэрт бүртгэл бүхий тээврийн хэрэгслээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх эрх олгосон баримт бичгийг хэлнэ,

“Тусгай зөвшөөрөл” гэж аль нэг Талын үндэсний хууль тогтоомж болон журмын дагуу олгосон тухайн улсын нутаг дэвсгэрээр нөгөө Талын тээвэрлэгчийн том оврын, онцгой хүнд эсхүл аюултай ачаатай тээвэрлэлт хийх нэг удаагийн нэмэлт зөвшөөрлийг хэлнэ;

“Тээврийн хэрэгсэл” гэж автобус, ачааны автомашин, чиргүүлтэй ачааны автомашин, авто зүтгүүр болон хагас чиргүүлтэй авто зүтгүүр зэрэг зорчигч болон ачаа тээвэрлэхэд зориулагдсан автотээврийн хэрэгслийг хэлнэ;

2 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн дагуу Талууд өөрийн улсын нутаг дэвсгэрээр аль нэг Талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээврийн хэрэгслээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх эрхийг тээвэрлэгчдэд олгоно.

3 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олон улсын автотээвэрлэлтийг Хэлэлцээрийн 1 дүгээр Хавсралтад заасан чиглэл болон улсын хилийг нэвтрэх хилийн боомтоор, Хэлэлцээрийн 2 дугаар Хавсралтад заасан зөвшөөрлийн бичгийг үндэслэн гүйцэтгэнэ.

2. Талуудын хоёр талт болон олон талт гэрээнд авто замын чиглэл болон улсын хилийг нэвтрэх хилийн боомтыг тодорхойлон заагаагүй, эсхүл өөр чиглэл, өөр хилийн боомтоор нэвтрэхээр заасан, эсхүл энэхүү Хэлэлцээрт заасан зөвшөөрлийн төрлөөс өөр төрлийн зөвшөөрлөөр, эсхүл зөвшөөрөлгүйгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэхээр тохирсон бол энэхүү зүйлийн нэгдүгээр заалт үл харшилна.

4 дүгээр зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн тээврийн хэрэгслийн ангилалд нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн



хэрэгслийн гэрчилгээг биедээ авч явна. Эдгээр баримт бичигт нутаг дэвсгэрээр нь олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэж буй Талуудын төрийн албан ёсны хэл дээрх баталгаажуулсан орчуулгыг хавсаргана.

2. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэл нь тухайн тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн Талын тээврийн хэрэгслийн улсын дугаар болон ялгах таних тэмдэгтэй байна.

3. Тал тус бүр бусад Талуудын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бүртгэлийн дугаарыг хүлээн зөвшөөрнө.

4. Аль нэг Талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээвэрлэгчийг нөгөө Талын нутаг дэвсгэрт эхлэх болон дуусах цэгийн хооронд зорчигч болон ачаа тээвэрлэхийг зөвшөөрөхгүй.

5 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт заасан шаардлагатай баримт бичиг, зөвшөөрлийг тээврийн хэрэгслийн жолооч биедээ авч явах бөгөөд эрх бүхий хяналт, шалгалтын байгууллагын хүсэлтийн дагуу шалгуулна.

6 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн жин, овор, бусад үзүүлэлтүүд, тэр дундаа тэнхлэгийн даац зэрэг нь нутаг дэвсгэрээр нь олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэж буй Талын үндэсний хууль тогтоомж болон журамд заасан шаардлагад нийцсэн байна.

2. Хэрэв аль нэг Талын ачаатай болон ачаагүй тээврийн хэрэгслийн овор болон жин нь нөгөө Талын үндэсний хууль тогтоомж болон журмаар өөрийн нутаг дэвсгэр дээр тогтоосон хэмжээ хязгаараас хэтэрсэн бол тээвэрлэгч нь тухайн Талын эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг авна.

7 дугаар зүйл

1. Аюултай ачааг Талуудын олон улсын гэрээ болон тухайн тээвэрлэлт явагдаж буй Талын нутаг дэвсгэрт үйлчилж байгаа үндэсний хууль тогтоомж болон журамд заасны дагуу тээвэрлэнэ.

2. Талуудын олон улсын гэрээ эсхүл үндэсний хууль тогтоомж болон журмын дагуу аюултай ачаа тээвэрлэхэд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай бол тээвэрлэгч нь тухайн улсын нутаг дэвсгэрээр тээвэрлэлт хийж эхлэхээс өмнө тухайн Талын эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг авна.

3. Талуудын эрх бүхий байгууллагууд аюултай ачааны жагсаалт болон өөрийн улсын үндэсний хууль тогтоомж болон журмаар тогтоосон тэдгээрийг тээвэрлэх нөхцөл шаардлагын талаарх мэдээллийг энэхүү Хэлэлцээрийн 12 дугаар зүйлийн дагуу байгуулсан Хамтарсан хорооны хүрээнд харилцан солилцоно.

8 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зорилгоор аль нэг Талын тээвэрлэгч өөрийн тээврийн хэрэгслээр нөгөө Талын нутаг дэвсгэрт оруулах дараах зүйлсийг гаалийн хураамж, төлбөр, татвараас харилцан чөлөөлнө:

- a) тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг түлшээр хангах зориулалтаар энгийн технологи, бүтэцтэй үйлдвэрлэгчийн хийсэн шатахууны саванд байгаа шатахуун, мөн халаах, хөргөх системд зориулж чиргүүл, хагас чиргүүлд үйлдвэрлэгчээс суурилуулсан саванд байгаа шатахуун;
- б) олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх явцад тээврийн хэрэгслийн хэвийн ашиглалтыг хангахад зайлшгүй шаардлагатай тосолгооны материал;
- в) олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх явцад эвдэрсэн тээврийн хэрэгслийг засварлахад шаардлагатай түр хугацаагаар оруулах сэлбэг, багаж хэрэгсэл.

2. Энэхүү зүйлийн 1.в) хэсэгт заасан ашиглагдаагүй сэлбэг, багаж хэрэгслийг буцаан гаргана. Мөн сольсон сэлбэгийг буцаан гаргах, эсхүл гаалийн устгалд оруулах үйл ажиллагаанд хамруулах, эсхүл сэлбэгийг сольсон тухайн Талын нутаг дэвсгэрт үйлчилж байгаа дотоодын гаалийн тухай хууль тогтоомж болон журмын дагуу бусад гаалийн үйл ажиллагаанд хамруулна.

9 дүгээр зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэхдээ Талуудын тээвэрлэгч нар тээврийн хэрэгсэл эзэмшсэн эсхүл ашигласан, мөн замын ашиглалт эсхүл засвар арчлалтын татвар, хураамжаас тус тус харилцан чөлөөлөгдөнө.

2. Талуудын тээвэрлэгчийн байгаа тухайн улсаас нь ялгаваргүйгээр тогтоосон зам, гүүр, нүхэн гарц ашигласны хураамж, төлбөрийг дээрх чөлөөлөгдөх зохицуулалтаас үл хамаарч төлнө.

10 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн дагуу олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэж буй тээвэрлэгч нь олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэж буй



Талын нутаг дэвсгэрт хүчинтэй, өөрийн тээврийн хэрэгсэлд хамаарах, гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх тээврийн хэрэгслийн зээмшигчийн иргэний хариуцлагын даатгалтай байна.

11 дүгээр зүйл

1. Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэж буй тээвэрлэгч болон тээврийн хэрэгслийн жолооч нь энэхүү Хэлэлцээрийн заалт, мөн тухайн үед тээврийн хэрэгслийн байгаа Талын үндэсний хууль тогтоомж болон журам, түүнчлэн замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй. Зөрчил гаргасан тохиолдолд нутаг дэвсгэр дээр нь зөрчил гарсан Талын үндэсний хууль тогтоомж болон журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

2. Аль нэг Талын нутаг дэвсгэрт нь давагдашгүй хүчин зүйл, эсхүл тээврийн хэрэгсэл, жолооч болон түүний баг, зорчигчдын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх замын хөдөлгөөний ноцтой осол эсхүл тохиолдол гарсны улмаас олон улсын автотээвэрлэлтийг үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсон бол тухайн Талын эрх бүхий байгууллага боломжит бүх туслалцааг үзүүлнэ.

12 дугаар зүйл

1. Талууд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хамтран хянах үүрэг бүхий тэдгээрийн эрх бүхий төлөөлөгчдөөс бүрдсэн Хамтарсан хороог байгуулна.

2. Хамтарсан хорооны ажлын удирдамж, үйл ажиллагааны чиг үүрэг, бүрэлдэхүүн болон Хамтарсан хорооны үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар Хавсралтад зааснаар тодорхойлно.

13 дугаар зүйл

1. Талууд олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэхтэй холбоотойгоор жолоочид виз олгох, хил гааль, тээвэр, ургамал амьтны хорио цээрийн хяналт шалгалтын үйл ажиллагаа, дүрэм журмыг хялбаршуулах чиглэлээр ажиллана.

2. Талууд эдгээр үйл ажиллагаа, дүрэм журмыг хялбаршуулах чиглэлээр авах тодорхой арга хэмжээнүүдийг тусгайлан тохиролцоно.

3. Хамтарсан хорооны хүрээнд олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэхтэй холбоотой баримт бичиг, дүрэм журам, шаардлагуудыг уялдуулах болон хялбаршуулах замаар олон улсын автотээвэрлэлтийг хөнгөвчлөх арга хэмжээнүүдийг судалж үзнэ.

14 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр болон түүний 1-3 дугаар Хавсралтуудад хамруулаагүй асуудлуудыг нутаг дэвсгэрээр нь олон улсын автотээвэрлэлт



гүйцэтгэж байгаа Талын үндэсний хууль тогтоомж болон журам, холбогдох олон улсын гэрээгээр зохицуулна.

15 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн 1-3 дугаар Хавсралтууд нь түүний салшгүй хэсэг болно.

16 дугаар зүйл

Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын журмыг хангасан тухай бичгээр үйлдсэн сүүлчийн мэдэгдлийг дипломат шугамаар илгээсэн өдрөөс энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

17 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсноос хойш 60 хоногийн дотор Талууд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцан ажиллах эрх бүхий байгууллагын талаар дипломат шугамаар харилцан мэдэгдэж, мөн өөрчлөлт орсон тухай бүр энэ талаар шуурхай мэдэгдэж байна.

18 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш зөвхөн бүх Талын зөвшөөрснөөр гарын үсэг зураагүй улсууд энэхүү Хэлэлцээрт нэгдэн ороход нээлттэй болно.

2. Энэхүү Хэлэлцээрт нэгдэн орох хүсэлтэй улс нь бүх Талуудад энэ тухайгаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

3. Энэхүү Хэлэлцээрт нэгдэн орох улс болон Талуудын хооронд байгуулах нэгдэн орох тухай нэмэлт протоколын зүйл заалтуудын дагуу энэхүү Хэлэлцээр нь тухайн нэгдэн орж буй улсын хувьд хүчин төгөлдөр болно.

19 дүгээр зүйл

Хэрэв өөрөөр заагаагүй бол Талуудын харилцан тохиролцооноор энэхүү Хэлэлцээрт тусдаа протокол байгуулах замаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тус протокол нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

20 дугаар зүйл

Аль ч тал энэхүү Хэлэлцээрээс гарч болох бөгөөд энэ тухай хүсэлтээ Хэлэлцээрээс гарахаар төлөвлөсөн хугацаанаасаа 6 сараас доошгүй хугацааны өмнө бусад Талуудад бичгээр мэдэгдэнэ.



Энэхүү Хэлэлцээрийг 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Москва хотноо монгол, англи, орос, хятад хэлээр тус бүр 3 эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр адил хүчинтэй байна. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах талаар санал зөрвөл англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

.....
/Гарын үсэг/

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

.....
/Гарын үсэг/

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

.....
/Гарын үсэг/

**АЗИЙН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭГЭЭР
ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН
1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**

**ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВЭРЛЭЛТИЙН
ЧИГЛЭЛ БА УЛСЫН ХИЛИЙН БООМТУУД**

1 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд гүйцэтгэж буй олон улсын автотээвэрлэлтийг дараах чиглэл болон улсын хилээр нэвтрэх хилийн боомтуудаар гүйцэтгэнэ:

АН 4

Новосибирск - Барнаул - Горно - Алтайск - Ташанта (ОХУ)
/Улаанбайшинт (Монгол Улс) - Ховд - Ярантай (Монгол Улс)
/Такешикан (БНХАУ) - Өрөмч - Каши - Хонгираф

АН 3

Улаан-Үд - Хиагт (ОХУ) /Алтанбулаг (Монгол Улс) - Дархан -
Улаанбаатар - Сайншанд - Замын-Үүд (Монгол Улс)/ Эрээн хот
(БНХАУ) - Бээжингийн гадна тойргоор - Тяньжин (БНХАУ)

2 дугаар зүйл

Талууд өөрийн улсын нутаг дэвсгэрт онц байдал үүсч, тэр нь үндэсний болон тээврийн аюулгүй байдалд нөлөөлөхөөр бол энэхүү Хавсралтад заасан чиглэл буюу/эсхүл улсын хилийг нэвтрэх хилийн боомтын үйл ажиллагааг хэсэгчлэн эсхүл бүтнээр нь түр хугацаагаар

зогсоож болно. Тухайн Тал энэ тухайгаа бусад Талуудад нэн даруй мэдээлж, нөхцөл байдал өөрчлөгдөн хэвийн байдалд орсон даруйд хязгаарлалтаа цуцална.

**АЗИЙН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭГЭЭР
ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН
2 ДУГААР ХАВСРАЛТ**

**ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВЭРЛЭЛТ
ГҮЙЦЭТГЭХ ЗӨВШӨӨРӨЛ**

1 дүгээр зүйл

Талууд энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр Хавсралтад заагдсан бүх чиглэлд болон улсын хилээр нэвтрэх хилийн боомтоор дамжин өөрсдийн нутаг дэвсгэрээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэхэд энэхүү Хавсралтад орсон зөвшөөрлийн маягтыг хүлээн зөвшөөрнө. Зөвшөөрөл нь хуанлийн нэг жилийн хугацаанд нэг удаагийн ирэх/буцах тээвэрлэлтэд хүчинтэй.

Талууд Хэлэлцээрийн 12 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан Хамтарсан хороонд орж ажиллах өөрийн эрх бүхий байгууллагад зөвшөөрлийн маягтад нэмэлт, өөрчлөлт оруулах болон бусад төрлийн автотээвэрлэлтийн үйл ажиллагаанд ашиглагдах зөвшөөрлийн маягтыг боловсруулж батлуулах эрхийг олгоно.

2 дугаар зүйл

Зөвшөөрлийн тоо хэмжээг Хамтарсан хорооноос тогтооно.

3 дугаар зүйл

Талууд энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар Хавсралтын 4 дүгээр зүйлд заасны дагуу ажиллаж байгаа Хамтарсан хороог даргалагч Талд зөвшөөрлийн маягтыг өмнө тохиролцон тогтоосон тоо хэмжээгээр хэвлэж бэлтгэн бусад Талуудад түгээх эрхийг олгоно.

4 дүгээр зүйл

Тал тус бүр өөрийн улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан энэхүү Хэлэлцээрийн заалт болон үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээвэрлэгчдэд зөвшөөрөл олгоно.

5 дугаар зүйл

Зөвшөөрлийн маягтыг бүрэн дүүрэн, засваргүй бөглөнө. Буцах тээвэрлэлтийн тухай мэдээллийг буцах тээвэрлэлтийг эхлэхээс өмнө зөвшөөрөлд оруулж болно.



6 дугаар зүйл

Зөвшөөрлийг түүнд заасан хуанлийн жилийн дотор ашиглах бөгөөд тухайн зөвшөөрлийг олгосон Талын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийг буцаж ирэх хүртэл хүчинтэй байна. Гэвч ямар ч тохиолдолд энэхүү хугацаа нь дараа жилийн 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хэтрэхгүй байна.

7 дугаар зүйл

Зөвшөөрлийг зөвхөн түүнд нэр заасан тээвэрлэгч ашиглах бөгөөд гуравдагч этгээдэд шилжүүлж үл болно.

8 дугаар зүйл

Хуурамч зөвшөөрөл ашигласан эсхүл гуравдагч талд шилжүүлсэн тохиолдолд уг нөхцөл байдлыг илрүүлсэн хяналтын байгууллага тухайн хуурамч зөвшөөрөл эсхүл гуравдагч талд шилжүүлсэн зөвшөөрлийг нэн даруй хураан авч, өөрийн улсын зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Хэрвээ тухайн эрх бүхий байгууллага нь хураагдсан зөвшөөрөлд дурдагдсан зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага биш байгаа тохиолдолд тухайн зөвшөөрөл дээр дурдсан зөвшөөрөл олгох дотоодын эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

9 дүгээр зүйл

Тээвэрлэгч өөрт олгогдсон зөвшөөрлөө үрэгдүүлсэн бол өөрийн улсын тухайн зөвшөөрлийг олгох эрх бүхий дотоодын байгууллагад энэ тухайгаа нэн даруй мэдэгдэнэ. Зөвшөөрөл олгох эрх бүхий дотоодын байгууллага зөвшөөрөл үрэгдүүлсэн тухай тээвэрлэгчийн энэхүү мэдээллийг хүлээн авсан даруйд тухайн үрэгдүүлсэн зөвшөөрлийн серийн дугаар, хүчингүй болгосон тухай мэдээллийн хамт бусад Талуудын зөвшөөрөл олгох эрх бүхий дотоодын байгууллагуудад мэдээлнэ.

10 дугаар зүйл

Зөвшөөрлийн маягыг тээвэрлэгчийн бүртгэлтэй улсын төрийн албан ёсны хэлээр бөглөж, тээвэрлэлт гүйцэтгэж буй чиглэлийн дагуух Талуудын төрийн албан ёсны хэл дээрх баталгаат орчуулгыг хавсаргана.



**ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВШӨӨРӨЛ
(МОНГОЛ, ХЯТАД, ОРОС ХЭЛЭЭР)**

Серийн дугаар: (Улсын код) 00000000
(монгол, хятад, орос хэлээр)

Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай
Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу энэхүү зөвшөөрлийг олгов
(монгол, хятад, орос хэлээр)

Он: (он тавих)
(монгол, хятад, орос хэлээр)

Зөвшөөрөл олгосон байгууллагын гарын үсэг, тамга (монгол, хятад, орос хэлээр)	Зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын гарын үсэг, тамга (монгол, хятад, орос хэлээр) (Гэрээний талын эрх бүхий байгууллагын гарын үсэг, тамга) Огноо: Байршил:	
	(1) Орох (монгол, хятад, орос хэлээр)	(2) Гаргах (монгол, хятад, орос хэлээр)



<p>1. Тээвэрлэгч байгууллагын нэр, хаяг (монгол, хятад, орос хэлээр)</p>		
<p>2. Ачааны машин/авто зүтгүүрийн бүртгэлийн дугаар/ улсын нэр (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>3. Ачааны машин/авто зүтгүүрийн загвар/ жин (кг) (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>4. Чиргүүл/хагас чиргүүлийн бүртгэлийн дугаар/ улсын нэр/ жин (кг) (монгол, хятад, орос хэлээр)</p>
<p>5. Ачааны (нэр) товч тайлбар, бохир жин (кг) (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>(1) Явах: (2) Ирэх: (монгол, хятад, орос хэлээр)</p>	
<p>6. Явах чиглэл: (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Чиглэлийн дугаар: Хаанаас: Хашаа: (монгол, хятад, орос хэлээр)</p>	
	<p>(1) Гарах (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>(2) Орох (монгол, хятад, орос хэлээр)</p>
<p>7. Ачаа хүрэх, дамжин өнгөрөх улсын хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалт, гарын үсэг/тамга (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Огноо: Байршил:</p>	<p>Огноо: Байршил:</p>
	<p>(1) Орох (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>(2) Гарах (монгол, хятад, орос хэлээр)</p>

<p>8. Ачаа хүрэх, дамжин өнгөрөх улсын хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалт, гарын үсэг/тамга (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Огноо: Байршил:</p>	<p>Огноо: Байршил:</p>
<p>9. Ачаа хүрэх, дамжин өнгөрөх улсын хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалт, гарын үсэг/тамга (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Огноо: Байршил:</p>	<p>Огноо: Байршил:</p>
<p>10. Ачаа хүрэх, дамжин өнгөрөх улсын хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалт, гарын үсэг/тамга (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Огноо: Байршил:</p>	<p>Огноо: Байршил:</p>
<p>11. Ачаа хүрэх, дамжин өнгөрөх улсын хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалт, гарын үсэг/тамга (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Огноо: Байршил:</p>	<p>Огноо: Байршил:</p>
<p>12. Ачаа хүрэх, дамжин өнгөрөх улсын хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалт, гарын үсэг/тамга (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Огноо: Байршил:</p>	<p>Огноо: Байршил:</p>
<p>13. Ачаа хүрэх, дамжин өнгөрөх улсын хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалт, гарын үсэг/тамга (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Огноо: Байршил:</p>	<p>Огноо: Байршил:</p>



<p>14. Ачаа хүрэх, дамжин өнгөрөх улсын хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалт, гарын үсэг/тамга (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Огноо: Байршил:</p>	<p>Огноо: Байршил:</p>
<p>15. Ачаа хүрэх, дамжин өнгөрөх улсын хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалт, гарын үсэг/тамга (монгол, хятад, орос хэлээр)</p>	<p>Огноо: Байршил:</p>	<p>Огноо: Байршил:</p>

Серийн дугаар (Улсын код) 000000000

Зааварчилгаа

1. Энэхүү зөвшөөрлийг дараах чиглэл эсхүл эдгээр чиглэлийн тодорхой хэсгүүд болон жилийн боомтуудаар ачаа тээвэрлэхэд ашиглана: (Тохиролцсон чиглэл, жилийн боомтууд).

2. Зөвшөөрлийг нэг улсын нутаг дэвсгэрт эхлэх болон дуусах цэгийн хооронд автотээвэрлэлт гүйцэтгэхэд ашиглахгүй.

3. Зөвшөөрлийг зөвхөн түүнд нэр нь заасан тээвэрлэгчид олгох бөгөөд гуравдагч этгээдэд шилжүүлж үл болно.

4. Зөвшөөрлийн маягтыг бүрэн дүүрэн, засваргүй бөглөнө. Буцах тээвэрлэлтийн тухай мэдээллийг буцах тээвэрлэлтийг эхлэхээс өмнө зөвшөөрөлд оруулж болно.

5. Хуурамч зөвшөөрөл ашиглах нь хууль бус үйлдэл бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх нөхцөл болно.

6. Зөвшөөрлийг түүнд заасан хуанлийн жилийн дотор ашиглах бөгөөд тухайн зөвшөөрлийг олгосон Талын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийг буцаж ирэх хүртэл хүчинтэй байна. Гэвч ямар ч тохиолдолд энэхүү хугацаа нь дараа жилийн 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хэтрэхгүй байна.

7. Тээврийн хэрэгслийн жолооч зөвшөөрлийг биедээ байнга авч явах бөгөөд хяналт шалгалтын эрх бүхий байгууллагын шаардлагаар шалгуулна.

8. Тээвэрлэгч нь олон улсын автотээвэрлэлт явагдаж буй Талын үндэсний хууль тогтоомж, авто тээврийн тухай зохицуулалт болон замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй.

(монгол, хятад, орос хэлээр)

**ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН
3 ДУГААР ХАВСРАЛТ**

ХАМТАРСАН ХОРООНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

1 дүгээр зүйл

Хамтарсан хорооны гол үүрэг бол энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

2 дугаар зүйл

Хамтарсан хороо дараах үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ:

1. Хэлэлцээрийн зүйл заалтуудыг жигд, уялдаатай хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хянан зохицуулах ба Хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад гарч болзошгүй асуудлуудыг шийдвэрлэх;

2. Хэлэлцээрт хамаарах чиглэл болон улсын хилийг нэвтрэх хилийн боомттой холбоотой нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх, улмаар Талуудаар батлуулах;

3. Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөлтэй холбоотой дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх:

- a. Зөвшөөрлийн тоо хэмжээ болон түүнийг тогтоох аргачлал;
- b. Зөвшөөрлийн маягтын загвар ба түүний агуулга, хэлбэр зэрэгт нэмэлт, өөрчлөлт оруулах;
- c. Зөвшөөрлийг хэвлэх арга, түгээх, ашиглах дүрмийг гаргах;
- d. Автотээвэрлэлтийн бусад төрлүүдэд хэрэглэгдэх зөвшөөрлийн маягтуудын загварыг боловсруулах, батлуулах.

4. Зөвшөөрлийн ашиглалтын бодит байдалд дүн шинжилгээ хийх, зөвшөөрөл олголтын тогтолцооны талаар тайлан бэлтгэх;

5. Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэхтэй холбоотой Талуудын дотоодод хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж болон журмын талаар Талуудын эрх бүхий байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлэх, аливаа нэмэлт өөрчлөлтүүд болон бусад мэдээллээр хангах;

6. Аюултай ачааны жагсаалт болон тэдгээрийг тээвэрлэх нөхцөл шаардлагын талаарх Талуудын үндэсний хууль тогтоомж болон журмын зохицуулалтын талаарх мэдээллийг харилцан солилцох;



7. Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх нөхцлийг сайжруулах саналыг боловсруулах;

8. Хэлэлцээрт хамааралтай бусад асуудлаар санал солилцох.

3 дугаар зүйл

Хамтарсан хороо нь Тал тус бүрээс Хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцсан үүрэг бүхий нэг төлөөлөгч, нэг орлогч төлөөлөгчөөс бүрдэнэ.

4 дүгээр зүйл

Хамтарсан хорооны даргаар англи хэлний цагаан толгойн үсгийн дарааллын дагуу Талууд жил бүр ээлжлэн ажиллана.

5 дугаар зүйл

Хамтарсан хорооны хуралд Хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцсан үүрэг бүхий үндэсний төлөөлөгч, мөн/эсхүл орлогч төлөөлөгч, хуралдааны хэлэлцэх асуудлын хүрээнээс хамаарч Талуудын холбогдох бусад байгууллагуудаас уригдсан төлөөлөгч, мөн Хамтарсан хорооны даргалагчаас Хамтарсан хорооны бусад гишүүдтэй санал солилцсоны дагуу урьсан холбогдох олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцоно.

6 дугаар зүйл

Хамтарсан хорооны хуралдаанаар нэгдмэл ойлголцолд хүрсний үндсэн дээр протокол үйлдэх байдлаар шийдвэр гаргана.

7 дугаар зүйл

Хамтарсан хороо нь жилд нэг удаа хуралдах бөгөөд аль нэг Талын хүсэлтээр бусад Талуудтай тохиролцсоны дагуу ээлжит бус/тусгай хурал зохион байгуулж болно.

8 дугаар зүйл

Хамтарсан хорооны жил бүрийн ээлжит хуралдааныг Хамтарсан хороог даргалж буй Талын нутаг дэвсгэрт зохион байгуулах бөгөөд ээлжит бус/тусгай хуралдаан хийх хугацаа, газар, хэлбэрийг Талууд хэлэлцэн тохиролцоно.

9 дүгээр зүйл

Хамтарсан хорооны хуралдааныг Талуудын албан ёсны хэлээр явуулна.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 200003